

**Чингис хааны тал нутгийн амь ахуйгаа хамгаалах үзэл  
ухамсыг туршин өгүүлэх нь**

**Баян\***

**Нэг. Чингис хааны тал нутгийн амь ахуйгаа хамгаалах үзэл ухамсрын хэлбэр**

**1. Амь ахуйгаа хамгаалах үзэл ухамсрын илрэх хэлбэр**

Чингис хааны байгуулсан Монгол хаант улс бол нэгэн мал аж ахуйгаар аж ахуйн сууриа болгосон төр гүрэн болох юм. Тал нутаг бол хамгийн үндсэн үйлдвэрлэлийн хэрэгсэл болно. Шимлэг сайн өвс бэлчээр, өвч ногоон уул хайрхан, цэвэр тунгалаг гол мөрөн, тэшин тоглосон амьтан гөрөөс бол улс гүрнийхэн оршин тогтнох бат бэх суурь нь болдог.

Эзэн богд Чингис хаан эрхээ хамгаалан бэхжүүлэхийн төлөө эдгээр бодит оршил ахуйгаас үүсч засаг төрөөс цэргийн явдал хүртэл, аж амьдрал зан заншлаас шашин шүтлэг болон соёл зэрэг талын хууль дүрмийг тогтоов. Үүний тухай Жүвэйни тэмдэглэсэн нь: “Өөрийн бодлоо үндэслэж (Чингис хаан- найруулагчаас) аливаа учир явдалд тус бүр нэг зурвас хууль тогтоон өгч, эл зүйлийн ялт хэрэгт бас цааз тогтоож өгөв. Учир нь татар хүн өөрийн бичиггүй тул тэр, монголын баатарчуудаа уйгур үсэг сур гэж зарлигдаж хэлсэн бөгөөд бас хамаа бүхий засаг болон хуулийг дэвтэрт тэмдэглэл хийв. Дэвтрийг “**Бүрэн засаг**” гэж нэрлэн, угсааны ван нарын ордонд хадгалав”, “Чингис хаан ноёрхлынхоо эхний үед монголын эл аймаг түүнийг дагасанд, монголын нийдэм баримтлаад ирсэн муу заншлыг таягдаад, оюун санааны үзэлтээс үзвэл магтууштай хууль дүрмийг тогтоож өгөв.”<sup>1</sup> Үүнээс үзвэл, Чингис хааны хууль цааз тогтоосон нь үнэн бөгөөд түүнээ “Бурхан засаг” гэж нэрийдэв.<sup>2</sup>

Энэхүү хуулийн бичиг дотор улс гүрний хамгийн үндсэн үйлдвэрлэлийн хэрэгсэл болох тал нутгийн амь ахуйг хамгаалах агуулга бүхий хууль цаазыг тогтоон, бодтой хэрэгжүүлэн эрс чангаар яллан шийтгэж, бүх нийгэм нийтийн муу заншилд цээрлэл үзүүлэн нэлээдийг үгүйсгэж чадав. Энэхүү бодтой үйлдлэгийн явцад буй болсон Чингис хааны амь ахуйгаа хамгаалах үзэл ухамсар нь тухайн нийгмийн малчин ардыг нөлөөлж зохих ахиулах үйлдлийг гаргаж чадсанаар үл барам Чингис хааны үр ач нар болох бусад хаад ноёдын дунд үргэлжлэн хэв маягаар

\* ӨМӨЗО, Ордос хотын Данс эвхмэлийн товчоо

<sup>1</sup> Жүвэйни зохиож Жэ Гао Цзи орчуулсан, “Дэлхийг дайлан дагуулагчдын түүх”-ийн 28-р нүүр

<sup>2</sup> У бай Чунь, Ко Янь, *Монгол хаант улсын дүрэм, үндэсний хэвлэлийн хороо* 55 нүүр; 59 нүүр;

хэрэгжүүлэгдсэн байна. Тэр нь малчин ардын дунд хэдэн үе цаашилбал хэдэн зуун жилийн түүхэн урт удаан хугацаанд охь сайн амь ахуйг хамгаалах зан заншил болж хоцроод, амь ахуй орчин тойрныг хайрлаж хамгаалан, байгаль нийгмийн тэнцүүртэй оршиход ахиулах үйлдлийг гаргаж чаджээ.

**Үг яриа үйл ажиллагаан дахь бодтой илрэл** Чингис хаан бол түүхэн дээрх агуу их улс төрчин, цэргийн эрдэмтэн болох бөгөөд амь ахуйгаа хамгаалах үзэл ухамсартай өвөг хаан байжээ. Эзэн Чингис амьд сэрүүн байхдаа үзэмжит сайхан эх байгаль амьтан гөрөөсдөө хэмжээлшгүй хайртай байж, нас нөгчсөнийхөө дараа ч үзэсгэлэн сайхан амь ахуйн орчин тойронд амарлингуй нойрсох даатгалаа хойч үедээ талбижээ. Эзэн хороо нутгийг хориул цаазын газар болгон амь ахуйг хамгаалдаг нь энэхүү гэрээсээс ч болов уу. Үүний тухай нэгэн эртний яриа Ордосчуудын дунд удаан жилээр уламжлагдан яригдаж байдаг:

*Богд Чингис хаан Тангудад аялах зам зуур эндэх Бор толгой гэдэг газраар өнгөрөхдөө барьсан ташуур нь гэнэт унасанд дагагсад нь дороо авч өгөх гэсэнд Чингис хаан ташуураа авуулсангүй: “Энэ лав нэгэн учир буй. Миний үзэхээр энэ газар өл буга бэлчээрлэлтэй, өвөөлжин шувуу өндөглөлтэй, эвдэрхий төрийг байгуулалтай, энэ бие жаргалтай их сайхан газар амуй, хожим намайг үхвээс энд оршуулбал зохимуй” гэж сургаал хайрласан гэнэ. Бас Чингис хаан ташуур унасан газрын байцыг ажиглаад: “Энэ газар баян сайхан газар байна. Баян Чанхаг гэвэл зохимоор байна” гэж хайрласнаас “Чанхаг” гэдэг нэр буй болсон юм гэнэ.*

Чингис хаан нас бараад чандрыг нь тээж үүгээр өнгөрөн гарахад хасаг тэрэг нь Чанхагийн голд шавардаад яасан ч гарахгүй болохоор амьд сэрүүндээ үүгээр өнгөрөхөд ташуур нь газар унасанд хэлсэн үгийг нь санаж энэ газар оршуулж гэнэ гэсэн уламжлал яриа буй. Зарим бууралчуудын хэлэхээр Чанхагийн голын баруун дээр бүхүй “Тогоо булаг” гэгч гүн булагт Чингисийн хүүрийг тээж явж байсан тэрэг шавардсан юм гэнэ. Тэр үед бас нэг зүйлийн юмыг тэр булгийн дотроос авч гаргаж чадсангүй орхисон гэж хэлэлцдэг. Бас зарим нь Чанхагийн голын зүүн шилийн цаадахь Шавартайн цайдамд шавардсан тул “Шавартайн гол” гэж нэрлэсэн гэдэг үг ч буй. Юу гэлээ гээд энэ хоёр газар нь Чингисийн чандрыг хадгалан тахисан цомцог ордны дэргэдэх газар юм. Чингисийн тухайн үед барьж байгаад унагасан ташуурыг нь шан болгон булаад овоо болгож тахиж гэнэ. Энэ овооны ор нь Эзэн хорооны зүүнтээ буй. Шар дархадын баруун яамтад жил бүрийн цагаан сарын шинийн гурванд онгон овоо болгож тахисаар хэдэн зуун жил болж байна. Чанхагийн голын баруун хойно таван газар зайтай шилд “Авч толгой” гэдэг газар буй. Энэ нь Чингис хааны буга авлаж энэ толгой дээр зогсож авын хишгийг хүртсэн гэнэ. Ингээд үүнийг нь дурсгаж “Авч толгой” нэртэй болж гэнэ.

Эдгээр уламжлал яриа нь монголчуудын түүхэн тулгар бичгийн зарим тэмдэглэлтэй хавилдаж байгаа газар буй. “*Хиадын үндсэн хураангуй алтан товч*”-д “Эзэн богд Есүй хатныг авч морьтон цэргүүдийг удирдан өөрөө мордвой. Эзэн богд өмнөөс хошууг үзээд” зарлиг болруун:

*“Эвдэрсэн төрд хоргололтой,*

*Энх төрд нутаглалтай,*

*Эдүгээ ирэх буга нутаглалтай хэмээн зарлиг болов”* гэж тэмдэглэжээ.

Бас тус номд чандрыг татсан хасаг тэргэний шаварт шигдсэн явдлыг тэмдэглэсэн бөгөөд “Өмнийн хөөвөр” гэгч газар хэмээн дурджээ. Мөн тус номд тэмдэглэсэн “Эзэн богд эндээс эчихүйдээ бахархан зарлиг болсны шалтгаанаар, эдүгээ хасаг тэрэг булны чинээн шигдвэй” гэсэн нь дээр дурдсан ардын яриатай нилээд ижилсэж буй.<sup>3</sup>

Энэхүү тэмдэглэлээс бид Чингис хааны өл буга бэлчсэн, өвөөлжин шувуу өндөглөсөн, өвч бүрхсэн ой шугуйтай, энх амгалан амь ахуйн орчин тойрныг дотоод сэтгэлээсээ хайрлаж, охь шилдэг тал нутгийн амь ахуйг баталж, нотлох овор сэтгэлгээг авч, жигүүртэн амьтангүй, тачир хувхай байгалийн орчин тойрон болгохгүй оврыг авсан нь ил тод харагдана. Амьтан гөрөөс, өвс ургамал, хүн, байгаль эе зохицонгуйгаар тэнцүүртэй сайхан оршсон амь ахуй орчин тойрныг Чингис хаан амьд сэрүүн байхдаа таашаан бахархаж байснаар үл барам бас нас нөгчсөнийхөө дараа ч тэнгэрийн орноос амь ахуйн сайн сайхныг бахран ерөөл даатгалаа талбижээ. Энэхүү үзэл ухамсар нь түүний хойчсыг нөлөөлж, эзэн Чингисийн онгоныг хориулын газар болгон шүтэн тахиж эдүгээ эринийг угтахад зохих үйлдлээ үзүүлжээ.

### **Хоёр. Чингис хааны тал нутгийн амь ахуйгаа хамгаалах үзэл ухамсар**

Түүхийн олон зүйлийн шалтгаан нөхцөлөөс болоод Чингис хааны тал нутгийн амь ахуй орчин тойрноо хамгаалах үзэл ухамсарын тухай үсэг бичгийн тэмдэглэл туйлын ховор тохиолдоно. Энд би эл төрлийн ном судраас цуглуулсан хэдэн жишээгээ доорх мэт хэдэн зурвас болгож тайлбарлахын дагуу эрдэмтдийн шинжилж судлахад зориулсугай.

#### **1. Тал нутгийн өвс бэлчээрийг хамгаалах үзэл ухамсар**

Чингис хаан бол Монгол хаант улсын анхны хаан болно. Монголчууд ер нь тал нутгийн өвс бэлчээрийн соргог сайхныг дагаж мал малжин амьдардаг малчин ард юм. Тэдний идэж уухаас аваад өмсөж зүүх, суух орон хүртэл бүр таван хошуу малын ашиг шимээс салж чаддаггүй юм. Идээний доторх улаан идээн ч болог, цагаан идээн ч болог бүр л мал сүргээс ирдэг, мал нь тал нутгийн өвс бэлчээрийг түшиглэдэг. Нэгэн мал аж ахуйгаар гол болгосон улс гүрэнд аваад хэлбэл тал нутаг гэх энэхүү газар дэвсгэр нь хамгийн үндсэн үйлдвэрлэлийн хэрэгсэл болсон байдаг. Хаан эзэн болсон Чингист аваад хэлбэл тал нутгийн амь ахуйн орчин тойрныг хамгаалах явдлыг оюун ухаандаа тунгаан бодолхийлэхгүй байхын аргагүй юм.

Түүхийн үйлдлэгийн явц дахь бодтой хэрэг явдалд тал нутгийн амь ахуйгаа хамгаалах аль олон ажил явдлыг хийж, дүрэм тогтоол хууль цааздаа хүртэл нямбай тогтоон хэрэгжүүлэн явагдуулж, үг яриа үйл ажиллагаагаараа хэдэн үеийг нөлөөлж байсан юм. Энэ тухай Чингис хаан өөрийнхөө “*Билиг сургаал*”-даа:

*“Хожим нь мөхөс би Алтай ууланд гараад цэргийн хүрээг харахад манай цэргийн олон нь шугуй мэт, цэргийг дагасан гэр бул нь олон байдаг. Мөхөс би тэдэнд амтат идээн идүүлж, гоё дээл өмсүүлж, сайхан гэрт суулгаж, шимлэг бэлчээрт малжуулахыг хүснэ. Зам гудааст бут ургамлыг бүрхүүлэх нь миний ашдын зурвас санаа билээ”<sup>4</sup>*

гэж сургаал хайрласан байдаг. Энд Чингис хаан зам гудааст бут ургамлыг бүрхүүлэх хүсэл зорилгоо илтгэсэн байна. Мөн ч Чингис хааны тал нутгийн амь ахуйгаа хамгаалах үзэл ухамсарынх нь бодтой илрэл болно.

<sup>3</sup> Сайнжаргал, Шаралтай, *Алтан ордны тайлга*, Үндэсний хэвлэлийн хороо, 3 нүүр.

<sup>4</sup> У бай Чунь, Ко Янь, *Монгол хаант улсын дүрэм*, Үндэсний хэвлэлийн хороо 55 нүүр; 59 нүүр;

Чингис хааны тал нутгийн өвс бэлчээрийг хамгаалах хуулийн тухай Тайваны Ли Зе Пень авгайн найруулж бичсэн: “*Чингис хааны шинэ намтар*” гэх номд “*Өвс ногоорсон хойно газрыг малтахыг хориулмуй*”<sup>5</sup> гэж тэмдэглэсэн байна.

Газрыг малтах нь газрын хөрсийг гэмтээж байгаа явдал мөн. Газрын хөрс нь хүний арьстай адил газрын гадаргууд удаан жилээр хурамтаж бий болсон туйлын шимлэг нарийн нанги шороон бүрэлдэхүүн юм. Түүнийг малтаж хөндөөвөл хүний арьс мах шагзалсантай адил эдгэрэхэд туйлын хүчиртэй бөгөөд нэн цаашлан салхи шуурган, үер усанд идэгдэн элсэрхэгжин цоорох үзэгдэл гардаг. Чингис хааны энд хэлж байгаа “*газар малтахыг хориглох*” хууль цааз дахь нэгэн урьдач нөхцөл бол “өвс ногоорсон хойно” гэх нөхцөл буй. Энэ үгэн дээрээс амь ахуй ногоорон сэргэсэн тал нутгийг эвдэж болохгүй гэх үзэл санаа туйлын ил тод харагдана. Урьхан хавар болж нялх ногоо үндэс хатгаж, дэвжээрэн ургах үед түүнийг уг үндсээр нь малтаж сүйтгэх юм бол эвдэгдсэн газар дахин амилан сэргэх бололцоогүй болно. Иймээс “*өвс ногоорсны хойно газрыг малтахыг хориглох*” нь амь ахуйг хамгаалах талаар чухал ач холбогдолтой юм.

Чингис хааны тал нутгийн амь ахуйгаа хамгаалах тухай бас: “*Гал алдаж бэлчээр шатаахыг цаазалмуй. Зорчигсдийн нэгэн гэрийг алмуй*”<sup>6</sup> гэх хууль цаазын зурвас буй. Гал алдаж бэлчээр шатахад хүрвэл их хэвчээнээ өвс бэлчээр бүхнээрээ бүр шатаж, мал сүрэг, амьтан гөрөөс, зэрлэг араатан, жигүүртэн шувууны идэх өвс ургамал сүйтгэгдэж, хүний амьдралын хэрэгцээг хүнд ноцтой нөлөөлөхөөр үл барам мал сүрэг хүнд ноцтой хорогдож хүний амь нас ч хөнөөгдөх явдал ч гардаг. Иймэрхүү хүний шалтгаанаас болсон тал нутгийн амь ахуйн хорогдол сүйдлийг чанга сэргийлэн хориглохын төлөө эрс чанга хууль дүрмийг тогтоосон явдал нь бүгд монголын дунд туушлагдан хэрэглэгдэж, сүүлээр нь ардын дунд эрс журамлах зан заншил болон хоцорсон байдаг.

## 2. Ой модыг хамгаалах үзэл ухамсар

Чингис хаан уул хайрхан, овоо онгодоо ой шугуй өвс модоор өвч бүрхэгдэж цэлгэр ногоон амь ахуй орчин тойронтой байхыг хүсдэг. Чингис хааны: “*Зам гудаст бут ургамлыг бүрхүүлэх нь миний ашдын зурвас санаа билээ*” гэсэн билэг сургаал нь түүний ой шугуйг хайрлан хамгаалах үзэл ухамсрыг илтгэж байгаа юм. Бага насны Тэмүжин Тайчуудын Таргудай Хирултагт цохигдож мөн Бурхан халдунд есөнтөө сөгдөж “*өчил өчин сацал сацаж*” байсан нь уул хайрхнаа сүсэглэн биширч хайрлан хамгаалж байсан үзэл ухамсрыг илрүүлж байгаа юм. Үүнээр үл барам Чингис хаан бөө мөргөлийн шашны ёс заншлыг нэлээд уламжлан баримталсаар байсан юм. Иймээс бөө мөргөлийн тухай зарим давшингуй мөртөө ой модыг хамгаалахад ашигтай зэрэг зан заншил нь мөн ч Чингис хааны баримтлах буюу улмаар хөгжүүлэх эсвэл туушлуулан хэрэгжүүлэх зүйл болж малчин ардын дунд түгээмэлжин дэлгэрсэн байдаг.

Доор бид эртний монголчуудын ой мод, уул хайрхан, овоо онгодын амь ахуй орчин тойрныг хайрлаж хамгаалж байсан байдлыг ажиглая.

<sup>5</sup> Ли Цзэ Фэнь, *Чингис хааны шинэ намтар*, Тайваны Жүн Хуа ном, 1970 он, 510 нүүр, Сайшаал, *Чингис хааны товчоон*” 498 нүүр, Цэгээ, *Эртний монголын амь ахуйг хамгаалах хуулийн тухай*, Өвөрмонголын нийгмийн шинжлэх ухаан, 2001. 2001.1-р хугацаа 21 нүүр;

<sup>6</sup> Мөн дээрх ном.

“Бөөгийн шашны газар дэлхийг шүтэж бишрэх сүсэг бишрэл нь уул овоог тахиж шүтэх дээр илэрч байхаар үл барам, ой тахилга буюу нэг хоёроор ургасан саглагар модыг тахиж шүтэх дээр илэрч байх юм. Арван гуравдугаар зууны үед монголын бөөгийн шашинтан хусан ойтой Хуст шүтээн гэдэг газар ба нарсан шугуйтай Нарст шүтээн гэдэг газраар тайлгын орноо болгож байсан нь ой шугуйг шүтдэг гэснийг харуулж буй. Тэрчлэн “Монголын нууц товчоон”-д гардаг Хархунаг гэдэг газар тэр газрын өнөөх “саглагар модон”-ыг бөөгийн шашныхан бүр ч их шүтдэг байсан аж.<sup>7</sup> Чингис хааны ой модыг хамгаалах үзэл ухамсрын тухай гадаадын монгол түүхэн эрдэмтэн Рашид-Ад-Дин “Судрын чуулган” гэх номдоо ингэж тэмдэглэсэн байдаг: “Тэндээс Чингис хаан бээр ан хийж байгаад нэгэн өнчин модны доор хүрч мориноосоо бууж сэтгэл өндөр хэлсэн нь “Энэ газар миний онгодыг байгуулбал харин болох юм байна. Энд нэг тэмдэг тавьцаа” гэжээ. Бэлэвсрэлийн үед түүний тэгж хэлснийг сонссон хүн ахиж хэлсэнд ноёд хийгээд нөхөд түүний зарлигийг дагаж тэр газрыг сонгож тогтоожээ. Сонсолтоор түүнийг оршуулсан тэр жил өвс мод тун сайн ургасан гэдэг. Анхны тэрхүү өнчин мод ба түүний оршуулсан газар нь нэгэнт танигдахын аргагүй болж, тэр газрыг хардаг хүмүүс хүртэл замаа олохгүй болсон гэнэ.”<sup>8</sup>

### 3. Усны ариун цэврийг хамгаалах үзэл ухамсар

Тал нутаг нь усны эх баялгаар нэлээд ховор чухаг байдаг. Эртний монголчуудын хүн малын ус унд нь голдуу урсгал мөрөн, булаг нуураас ирэлттэй юм. Иймээс усны ариун тунгалгийг баталж арвитай гамтай ашиглах нь малчин ардын амьдрал ахуйтай холбогдох чухал асуудал болох юм. Чингис хааны тал нутгийн амь ахуйг хамгаалах үзэл ухамсар нь усны ариун цэврийг хамгаалах үзэл ухамсар дээр илэрнэ. Чингис хаан дайн байлдааны хатуу бэрх цаг мөчид Бэлчис голын усыг цэрэг байлдагчидтайгаа хамтаар өргөн цугаар балгаж анд ах дүү барилдаж, Хөх мөнх тэнгэрт тангарагласан байдаг. Энд Чингис хаан гол мөрний усаа архи сархад мэт хүндээр үзэж байсан нь тодорхой мэдэгдэнэ.

Энэ тухай “Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл” гэх номд: “Чингис хаан ану Ван хаанд элч илгээгээд даруй Хонгирадын өөр нэг аймаг болох Нурхиныг дээрэмдэн олзолж Бэлчис гол дээр хүрч усыг ууж олон дугаа андгайлбай.” гэж тэмдэглэсэн байдаг. Чингис хаан тал нутгийн усыг ариун цэвэр арвитай гамтай ашиглахын төлөө: “Ард иргэд усанд гараа дүрж болохгүй, ус авахдаа заавал багаж сав хэрэглэнэ. Дээлээ нэг мөсөн элэгдэж барахаас өмнө угааж болохгүй.” гэсэн хууль цааз тогтоосон байна. Бас Чингис хааны засагт: “Ус ба үнсэнд шээсээ хийгчийг ална.” хэмээн нарийн цааз тогтоож эрсээр шийтгэсэн байна. Эдгээр нь бүр усны ариун цэврийг хамгаалж, хүн амьтны ус ундааг баталж, өвчин хижгийг сэргийлэхийн төлөө юм.

### 4. Араатан амьтныг хамгаалах үзэл ухамсар

Чингис хааны хүрээ ав хийхийн зорилго бол нэгд амьдралын нөхвөр болгохын төлөө, хоёрт цэргийн боловсрол хийхийн төлөө юм. Хүрээ авыг аван үзэхэд амьтан гөрөөсийг бүгдийг хамран үлдээлгүй устгадаг шиг боловч тэр нь тийм биш юм. Чингис хааны тогтоосон хууль дүрмийн дотор хүрээ ав хийхэд цаг хугацаа, хүрээ хэвчээ, хэлбэр маягийн талаар нарийн

<sup>7</sup> Г.Буянбат, *Монголын бөөгийн шашны учир*, 14 нүүр.

<sup>8</sup> Б.Баян, “Ордосчуудын амь ахуйгаа хамгаалах зан заншил”-даа Рашид-Ад-Дин: “Судрын чуулган” дахь I ботийн 4-р хуваарь дэвтэр дэх 322-323 нүүр дээрх агуулгыг эшилсэн.

тогтоосон байна. Эдгээр нь хэмжээ хязгаартай ан агналыг хийж, хээрийн амьтан гөрөөсийг хамгаалж, тал нутгийн тэнцүүрийг батлах зорилгодоо хүрэхийн төлөө байдаг.

Юань улсын үед хээрийн амьтныг хамгаалах хууль дүрэм дотроо ан агналын цаг хугацааны талаар: *“Цагаан сараас зургаан сарыг тогтөл хээлтэй амьтныг алж болохгүй”*<sup>9</sup> гэдэг зурвасыг тогтоожээ. Их хаан ав хийх туйлын дуртай байсан юм. *“Юань улсын судар”*-т тэмдэглэсэнээр: *“Тэр бээр ав гөрөөд дур бахтай боловч, өвөг дээдсийн хууль дүрмийг журамлаж өөрийн зоригоороо хуучин хэвшлийг эвддэггүй”* гэжээ.<sup>10</sup> Иванинь: *“Тэмүжин төмрийн цэрэг хэрэглэхүй арга”* гэдэг номдоо ингэж тэмдэглэжээ. “Чингис хаан ав хоморго тавих явдлаар цэргээ боловсруулах нь мэдээжийн хэрэг билээ. Тэр үе хүүхэд ач нартаа сургаж хэлсэн нь: *Ав хоморго хийх бол хаан хүний үйл ажил юм* гэжээ. Хааны ав хоморгын цаг бол өвлийн эхэн үе аж. Ав тавихдаа урьдаар албан хүмүүсийг томилон ав хийх газрыг тогтоон, дараа нь нутгийн иргэдийн доторх идэр залуучуудаар хээр талын ан гөрөөсийг хомрон цуглуулах ажил хийлгэнэ. Цэргээ гол цэрэг, зүүн жигүүр, баруун жигүүр гэж гурван хэсэгт хуваагаад жанжин үүнийг ерөнхийлөн захирна. Гэвч ийм үед бол цэргийн ноёдууд хатнаа дагуулан оролцохыг зөвшөөрч байжээ. Цэрэг хөдөлж ав эхлэх үед жанжин нар зүг бүрээс хөөж ирсэн гөрөөсийн тойм тоо болон байх газрыг хаанд мэдүүлээд хоморгын хүрээгээ улмаар багасган бараг нэг дөрвөлжин газрын хэвчээтэй болгоно. Дөрвөн талаас бүсэлж ирсэн цэргүүд үнэхээр үүл хурсан мэт болж шивээ шаах газаргүй болтол эгнэн зогсоно. Ингээд ан амьтны үсээр томсон дээсээр цагираг татах бөгөөд хэрвээ аль нэгэн цэрэг хоморгын дотор байх ан амьтныг алдаж дутаалгавал алжуу залхууд тооцогдож зохих шийтгэл олно. Хоморгын хүрээг шахаж дуусмагц хаан юуны өмнө хатад болон дагагсдаа дагуулан хоморгын дотор орж авлана. Хаан авлаж дуусаад хаан хатад тусгай бэлтгэсэн тавцан дээр гарч зогсоод язгууртан ноёд ба жанжин цэргүүдийн ав хийхийг бараалан үзнэ. Ав бараг хэдэн өдөр үргэлжлэх бөгөөд ан амьтдыг бараг цөмийг алж дуусахын үеэр өвгөд насад хааны майханд бараалхаж хээр талын ан амьтны хойшдын үржлийг харгалзахын тулд хэдэн толгой үлдээж соёрхох болов уу гэж гуйчлалт гаргана. Энэ үед ан хийх ажил зогсож олзын юмаа хуваалцаад гэртээ буцна. Ав хоморго бол тийн байлдаантай дэмий их зөрөөгүй аж.”<sup>11</sup>

Эдгээр агуулгаас бид Чингис хааны хүрээ ав нь дан ганц ард цэргийн амьдралын ашиг тусыг шийдвэрлэх зорилго биш харин цэрэг ангийг давтан боловсруулах цэргийн сургууль мөн болохыг мэдэж болно. Нэн чухал нь амьтан гөрөөсийг бүхнийг алж устгах биш харин нэг бүлгийг үлдээн хойшдын өсч үржихийг харгалзаж байгалийн тэнцвэрийг батлах зорилгодоо хүрдэг байжээ. Энэ тухай тусгай эрдэмтэн Цэгээ нөхөр:

*“Хүрээ авыг цэргийн боловсролын арга хэлбэр болгож байсан явдлыг нөгөө талаас нь задалбал, тухайн үед тал нутгийн орчин ахуй өргөн, ан гөрөө олон байсан боловч, хүрээ ав хийгээд тэр бүхнийг алж дуусгах биш. Хэрэгцээ бүхий эх, нялх ангийн гөрөөг тавьж үлдээдэг байсан. Ингээж хийдгийн учир нь хээрийн амьтны үржсиж өсөхийг батлах мөртөө амь ахуйн тэнцүүрийг баталж*

<sup>9</sup> Сталин, *Засаггүй үзэл юм уу, нийгэм журам уу?*, Сталины бүрэн зохиолын хятад хэвлэлийн 1-р ботийн 290, 291-р нүүр, Иванин, *Тэмүжин Төмөрийн цэрэг хэрэглэхүй арга*, 60-р нүүр

<sup>10</sup> У бай Чунь, Ко Янь, *Монгол хаант улсын дүрэм*, Үндэсний хэвлэлийн хороо 55 нүүр; 59 нүүр; Л.Хурцбаатар, *Хатагш арван гурван атаа тэнгэрийн тайлга*, 11 нүүр, 57-61 нүүр

<sup>11</sup> Цэгээ, *Эртний монголын амь ахуйг хамгаалах хуулийн тухай*, Өвөрмонголын нийгмийн шинжлэх ухаан, 2001.1-р хугацаа

чаддаг юм.” Монгол хаант улсын үеийн иймэрхүү үнэн бодит байдлыг гадаадын эрдэмтэн Жүвэйни нарийн тэмдэглэсэн байдаг: “Энэ үед өвгөд болон цагаан сахалт настан хичээнгүйлэн дэвшиж, хааны дэргэд хүрч очоод түүний аз жаргалын төлөө даатгал залбирал тавьсны дараа, амьд үлдсэн араатныг алалгүй орхиж, ус бэлчээр сайтай газар руу явуульга хэмээн гуйдаг аж. За, тэгээд агнаж олсон байдаг араатнаа цуглуулаад, эл төрлийн амьтны тоо толгойг авч чадахгүйд хүрвэл зөвхөн догшин араатан болон чихтийн тоог бүртгээд ав тайлна. Миний нэгэн найз энэ тухай өгүүлэхдээ хааны ноёдлын үеийн нэгэн өвөл, тэд дурдсан ёсоор ан тавив. Авын үзэмж үзэхийг бодсон хаан нэгэн бяцхан уулын орой дээр гарч суужээ. Тэгтэл элдэв зүйлийн араатан амьтны уулын хормой дороос хаан өвд хандацгаан эмгэнэлтэйгээр орхирч гашуудалтайгаар улилдав. Энэ нь яг аврал эрсэн хааны голч байхыг гуйж байгаа мэт харагджээ. Хаан зарлиг буулгаж тэдгээр араатныг нэг ч шархдуулалгүй бүхнээр нь талбиж гаргав.”<sup>12</sup> гэж буй.

Чингис хаан бөө мөргөлийн шашныг зохих хэмжээгээр шүтдэг. Иймээс бөө мөргөлийн зарим цээр ёсон, дүрэм горим нь шашны үйл ажиллагаагаар дамжин нийгмийн бодит үйл ажиллагаанд үйлдлээ үзүүлсэн байна.

Монголчууд нь бугыг өөрсдийнхөө онгод шүтээн болгон тахиж байв. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ноён уулын булшыг малтахад: “Гоо марлын зурагтай дэвсгэр” олдсон бөгөөд халх монголын бусад газарт бугын зурагтай чулуун хөшөө арвин байдаг гэнэ.<sup>13</sup> Балар эртний үеийн хүмүүс нь ан агнан амьдрахдаа, өөрсдийнхөө гайхаж биширсэн буюу айж сүрдэдсэн ямар нэгэн араатан жигүүртний дүрсийг мод буюу чулуугаар үйлдэн бүтээгээд тахиж шүтдэг байжээ.

## 5, Арвилан гамнах үзэл ухамсар

Арвилан гамнах нь үнэндээ эх байгалийн эх сурвалжыг арвилан гамнаж байгаа юм. Хүний идэж, өмсөх, суух, хэрэглэх, хэрэгцээ бүхий зүйл нь бүр эх байгалиас ирэлттэй байдаг. Иймээс арвилан гамнаж байгаа нь мөн ч амь ахуйн орчин тойрныг хамгаалж байгаа явдал мөн. Чингис хааны амь ахуйгаа хамгаалах үзэл ухамсар нь арвилан гамнах үйл ажиллагаан дээр илэрнэ.

Эртний монголчууд мал сүргээр амьдралын хэрэгцээгээ хангахаас гадна бас хээрийн амьтныг агнаж амьдралын нөхвөр болгож байв. Ан амьтны махыг идэхээр үл барам гэдэс дотор, толгой шийрийг ч идэж, хэмжээтэй хээрийн амьтныг арвилан гамнаж идэх тухай Чингис хаан цэрэг ардаа зааварлаж байсан юм. Иваниний зохиосон, “**Тэмүжин төмрийн цэрэг хэрэглэхүй арга**” гэх номд: “Элсэн говь хээр цөлд аян дайн хийхэд хоол хүнс дутагдах явдал бол ердийн хэрэг болох учир Чингис хаан адгуусан амьтныг алахад түүний цусыг ашиглатуугай гэж зарлиг болсон байна. Ан амьтны цус бол хоол хүнсний нөхвөр болох тул амьтныг алахдаа эрхбичи дөрвөн мочийг нь хүлэж гэдсийг нь хагалаад зүрхийг татаж цусан судлыг нь тэмтрэн албал зохино. Ингэвэл цус гадагш урсахгүй байж чадна. Энэ бол цус (монголчууд мал алмагц цусыг гэдсэнд цутгаж идэх заншил одоо хүртэл үргэлжилж буй-хянагч)-ыг хаяхгүй идэхийн төлөө юм. Гэтэл Исламынхны мал адгуус алах арга бол үүнээс өөр тул Чингис хаан их дургүйцдэг байжээ. Идэж болох бүхэн (цус, гэдэс дотор, толгой

<sup>12</sup> Цэгээ, Эртний монголын амь ахуйг хамгаалах хуулийн тухай, Өвөрмонголын нийгмийн шинжлэх ухаан, 2001.1-р хугацаа 21 нүүр;

<sup>13</sup> Мөн дээрх ном.

*шийр зэрэг)-ийг ариун юмаар үзэхээс биш бузар гэхийг Чингис хаан цээрлэж байв. Гурван сараас арван сар хүртэлх хугацаанаа буга, янгир ямаа, хулан, жигүүртэн шувуу зэрэг аливаа ан амьтныг агнаж үл болно гэж цаазлав. Эдгээр ан амьтан бол нүүдэлчин иргэдийн амьдралд тус нэмүүр болох учир түүний үржихийг эрмэлзсэнээс ийм хугацаа тогтоожээ. Нөгөөтэйгүүр нүүдэлчин иргэд бол зуны улиралд идээн ундаанаар дэмий гачигдахгүй байдгаас болж буй.”<sup>14</sup>*

Чингис хаан амьдралын зан даатгалын талаар хүүхэд ач нараа амьдралдаа борогжуун байх, бүрэлгэн сүйтгэж болохгүй гэж сургаж хүмүүжүүлдэг. Тэр **“Билиг сургаал”**-даа, *“Хүүхэд дүү нараа цаг ямагт сургаж, угийг нь мартуулж болохгүй. Тэдэнд зовхон өнгөтэйг өмсөөд амттайг идэхийг сургаад болохгүй. Мөн ч сайн хүлэг унаад, гоё эхнэртэй нь жаргуулаад л байж болохгүй. Ийм биш бол манай үйлсийн бүтээсэн гашуун зүдүүрийг мартаж орхих болно.”* гэжээ. Тэр бас хэлсэн нь: *“Миний хойч үрс алт хасыг өмсөж, амтат идээнийг зооглож, ажнай хүлгийг унаж, амраг хатантайгаа жаргахдаа: “Эдгээрийг цөм манай эцэг ах нар олж өгсөн” гэж хэлэхгүй юм. Тэд бидний энэхүү агуу их өдрүүдийг мартаж гэж байна!”* гэв.<sup>15</sup>

**Гурав. Чингис хааны тал нутгийн амь ахуйгаа хамгаалах үзэл ухамсрын буй болсон нь** Чингис хаан бол Дундад улсын түүхэн дэх шалгарсан цэргийн эрдэмтэн бөгөөд улс төрчин, бодлоготон мөн. Түүний насан туршийнх нь үйл ажиллагаа, үг ярианд, цаашилбал үсэг бичгээр тэмдэглэж хоцоргосон хууль цаазад нь тал нутгийн амь ахуйгаа хамгаалах үзэл ухамсар туушлагдан илэрч байгааг холбогдол бүхий түүхэн тэмдэглэлээс олж мэдсэн байна. Эдгээр үзэл ухамсар нь хэрхэн буй болсон, түүний уг ирэлт нь чухам юу болох тухай улам нэг алхам ойлгох чухалтай юм. Чингис хааны тал нутгийн амь ахуйгаа хамгаалах үзэл ухамсар нь Чингис хааны **“Тэнгэрийн хүчний үзэлт”**-ээс ирэлттэй юм. Тэр нь Чингисийн балчир бага насны бишрэн шүтэж байсан **“тэнгэр”** ба сүүлээр нь нийт монголчуудын тахиж байсан **“Хөх мөнх тэнгэр”**-ээс хөгжөөд буй болсон **“Тэнгэрийн хүчин”** зэрэг адил бус хөгжлийн явцад тасралтгүй хөгжин хувирч буй болсон байна.

Чингис хааны дээдэс нь ч тэнгэрийг тахиж байсан юм. Дээдсийнх нь тахиж байсан тэнгэрийн тахилга нь Чингис хааны сүсэг бишрэлийн буй болоход шууд нөлөө үзүүлсэн байдаг. Чингис ч бодтой түүхэн орчин тойронд амьдарч байсны бодтой хүн болох учраас тэр нь нийгмийн тухайн үеийн нөлөөг хүлээх нь зайлшгүй юм. Марксаас **“Хүмүүсийн үзэл ухамсар нь хүмүүсийн оршихуйг тогтоодог биш, харин хүмүүсийн нийгмийн оршихуй нь хүмүүсийн үзэл ухамсрыг тогтоодог юм.”**<sup>16</sup> Хүн бол нийгмийн ерөнхийлөл мөн гэж үздэг бөгөөд хүн нь нийгмийн нөхцөлийг хүлээж, түүний нөлөөнд гүн нөлөөлөгддөг юм гэдэг.

Чингис хааны дээдсийнх нь тэнгэрийн тахилгын тухай Л.Хурцбаатар нөхөр: **“Хатагин арван гурван Атаа тэнгэрийн тайлга”** гэх номдоо Бугу хатагигаас үүсэлтэй Ордос хатагин

<sup>14</sup> Г.Буянбат, *Монголын бөөгийн шашны учир*, 14 нүүр, Иванин, *Тэмүжин Томөрийн цэрэг хэрэглэхүй арга*, 60-р нүүр

<sup>15</sup> Цэгээ, *Эртний монголын амь ахуйг хамгаалах хуулийн тухай*, Өвөрмонголын нийгмийн шинжлэх ухаан, 2001.1-р хугацаа

<sup>16</sup> Жүвэйни зохиож Жэ Гао Ци орчуулсан *“Дэлхийг дайлан дагуулагчдын түүх”*-ийн 28-р нүүр, Л.Хурцбаатар, *Хатагин арван гурван атаа тэнгэрийн тайлга*, 11 нүүр, 57-61 нүүр



овогтны эрхшүүлэн тахисаар ирсэн *“Хаадын гэрийн арван гурван атаа тэнгэрийн тайлга”*-ын доторх *“Хаадын гэрийн тайлга”*-ыг нилээд нарийн өгүүлсэн байдаг: *“Хаадын гэрийн тайлга”* гэдэг нь эртний *“Монголжин улс”*-ын *Нирун аймгийн овог төрлийн тайлга* болно. *Өөрөөр хэлбэл, Дээд тэнгэрээс заяат төрсөн”* Бөртэ чонын үрдэс хан язгуурт Боржигин овогт Боданчирын тайж тахидаг гэрийн тайлга зүхэл тайлгыг заана. Зүхэл тайлга гэдэг нь ихсийн газарт зүлд модонд өлгөчихөөд бүх овог аймгаараа цугларч тэнгэр тахигдаа өөрийн биеийн гарал угсаа удам (овог)-аа мэдэрч авах тайлга мөргөлийг хэлнэ.<sup>17</sup>

Иймэрхүү угсаа удмаа мэдрэх тайлга-Тэнгэрийн тухай тахилга нь Бөртэ чоноос Чингис хааны үе хүртэл уламжлагдаж ирсэн бөгөөд балчир бага насны Тэмүжиний оюун ухаанд гүн нөлөө үзүүлсэн байдаг. Тэмүжин Тайчуудын довтлолтоос дутааж, гүн уулын бэрх шугуйд нуугдаж байхдаа *“Тэнгэр”* гэх үгийг хоёр удаа хэлсэн байдаг. Даруй *тэнгэрийн санаа надыг өршөөсөн* гэсэн санаагаа илтгэжээ. Энэхүү анхны шат үед, Тэмүжиний зориг зүрх, ухаан чадвар аль бүхэн нь цөм боловсроогүй буюу яг аажмаар бүрэлдэн тогтнох зүгтээ хөгжиж байсан юм. Мөн үүний зэрэгцээгээр Тэмүжиний ертөнцийн үзэлт ч яг эхлэн бүрэлдэж байсан юм. Гурван мэргэдийн дайралтаас Тэмүжин амь мэнд гараад *“нарны эсрэг бүсээ хүзүүндээ сээжиглэж, гараа өвчүүндээ мөөлдөж, наран зүг есөнтөө сөгдөж цацал өчүүл өгөв”* Эдгээр илрэл нь түүний үзэл ухамсарт бөөгийн шашны гол шүтээн болсон *“тэнгэр”*<sup>18</sup> нь шүтэн бишрэгдэж байсан нь илхэн байна.

1189 онд Тэмүжин Монгол аймгийн хаанаар сонгогдох үед, нэг бүлэг бөө нар ихээхэн хүч өргөж нийгэм дээр нөлөө үзүүлсэн юм. Тэдгээр бөө нар голдуу *“Тэнгэрийг ашиглаж, нийгмийн яриа хэлэлцээг өргөнөөр хийснийг Тэмүжин тодорхой таньж олоод, уулын үхмэлээр бишрэн шүтэж байсан суурь дээр санаачлагат агуулга нэмж, өөрийн үйлсдээ органикаар ашиглаж эхэлжээ. Чингис хааны дурдсан Тэнгэрийн өмнө “мөнх” гэдэг тодотгол нэмж “Мөнх тэнгэр” -ийн үзэл санаа буй болсон байна. Хойно нь “хүчинд ивээгдэж гэдэг уян хатан чанартай үйлдлэгийн шинжит шинэ агуулга нэмэгдсэн нь тодхон байна.”*<sup>19</sup>

Энэхүү Чингис хааны *“Тэнгэр”*-ийн хүчний үзэл санааны тухай Төвийн үндэстний дээд сургуулийн Түн Дэ фү эрдэмтэн нэн нарийн нямбай ярьсан байдаг: *Чингис хааны гүн ухааны үзэл санаа нь Чингис хааны улс төрийн зорилтод үйлчлэхэд улам дөхөм хялбархан, шууд шулуун, ил тод зүйл болсон байна. Сэтгэлч үзлийн ертөнцийн үзэлт болох “тэнгэрийн хүчний үзэлт” нь Чингис хаанд зөвхөн назгай бөгөөд үхмэл итгэл бишрэл биш, харин өөрийн цэрэг ардаа зэвсэглэж, тэдний хаан эзэндээ үнэнч шударга болгох ба үйлстээ эрхбиш ялалт олох итгэл бишрэлтэй болгох үзэл санааны зэвсэг болжээ. Энэ нь бид Чингис хааны “мөнх тэнгэр” -ийн тухай үзэл санааг “Тэнгэрийн заяаны үзэлт” гэхгүй, харин “Тэнгэрийн хүчний үзэлт” гэж байхын гол үндсэн баримт болно. Чингис хаан бол “Тэнгэрийн хүчний үзэлт” -ийг бишрэн шүтэгч мөн. Гэхдээ тэр урьдахь хүмүүсийнхээ “мөнх тэнгэр” -ийн тухай үзэл санааг дөхөмхөнөөр мөрдөн баримталсан биш. Тэр нэгэн шалгарсан улс төрчин болсон хувьд урт хугацаагаар сарнин бутраад харилцан дайсагнах буюу самуун дайн дэгдээж байсан эл аймаг бүлгүүдийг хүчээр нэгтгэсний дараа, өөрийн эрх хүчин ба байр сууриа*

<sup>17</sup> Г.Буянбат, *Монголын бөөгийн шашны учир*, 14 нүүр

<sup>18</sup> Иванин, *Тэмүжин Төмөрийн цэрэг хэрэглэхүй арга*, 60-р нүүр

<sup>19</sup> У бай Чунь, Ко Янь, *Монгол хаант улсын дүрэм, Үндэсний хэвлэлийн хороо* 55 нүүр, 59 нүүр; Л.Хурибаатар, *Хатагин арван гурван атаа тэнгэрийн тайлга*, 11 нүүр, 57-61 нүүр

бататгаж, ангийн ашиг тусаа хамгаалахад эрхбичи оюун санааны хүчээр хүмүүсийн үзэл санааг захирч, олны сэтгэлийг олох хэрэгтэй гэдгийг тодорхой мэдэж байжээ. Ингээд, тэр монголын нийгэм дэх “**Мөнх тэнгэр**”-ийн тухай удамшилт үзэл санааг ашигласнаар барахгүй, түүнд шинэ агуулгуудыг оруулаад, өвөрмөц онцлог бүхий “Тэнгэрийн хүчний үзэлт”-г буй болгосон байв. “**Мөнх тэнгэр**”-ийн ивээл соёрхолд назгай найдлага тавихгүй, хувь заяа ерөөл тавилангаа ч хүлээхгүй, ирэх төрлийн цэнгэл жаргалыг ч хий хүсэхгүй, харин тэнгэрийн хүчийг ашиглаж, дараа нь хүний хүчийг гаргах, тэмцэж байгаад хувь заяагаа хувируулж, улс төрийн зорилтоо биелүүлэх бол Чингис хааны “**Тэнгэрийн хүчний үзэлт**”-ийн нэгэн чухал онцлог болно.<sup>20</sup>

Дээрх эрдэмтдийн судалгааны үр дүнгээс бид Чингис хаан “тэнгэрийн хүчин”-ийг шүтэж байсан бөгөөд бөө мөргөлийн шашныг зохих хэмжээгээр ашиглан шүтэж байсан юм гэсэн дүгнэлтийг гаргаж болно. Тэнгэрийн тухай шүтээн бол бөө мөргөлийн шашны доторх хамгийн гол шүтээн нь болно. Монголын бөө мөргөлийн гол шүтээн нь ерэн есөн тэнгэр байдаг. Ерэн есөн тэнгэрийн өвөг тэнгэр бол “**Хөх мөнх тэнгэр**” болно гэж Хайсиг авгай “**Монголын шашин суртахуун**” гэдэг номдоо өгүүлсэн нь зөв юм. Эдгээр ерэн есөн тэнгэрээс заримыг нь сонгож ярьвал:

*Мялаан тэнгэр* - бас Эх малын тэнгэр гэж хэлдэг,  
*Тэх тэнгэр*- Ямаан тэнгэр,  
*Зол тэнгэр*-үхэр арвижуулах тэнгэр  
*Хүжир тэнгэр*-хүн малын идэш ууш өгөх тэнгэр  
*Мал галын дархан хүжир тэнгэр* - өндөр эвэртэй араатан амьтныг хамгаалах тэнгэр,  
*Манаан тэнгэр* - ангийн тэнгэр, гөрөөс амьтныг хамаарч байгаа тэнгэр  
*Тарианыг арвидах тэнгэр*-хураалт олгох тэнгэр  
*Хур буулгах тэнгэр* - бороо оруулах тэнгэр,  
*Анарва тэнгэр*-гоё сайхан өнгийг хамгаалах тэнгэр  
*Ари галын тэнгэр* - галын эзэн тэнгэр зэрэг ерэн есөн тэнгэр байдаг гэнэ.<sup>21</sup>

“**Хөх мөнх тэнгэр**”-ийн доорх ерэн есөн тэнгэр нь бүр бодтой агуулга ба бодот бодисыг хамгаалах ба жолоодох тэнгэр болсон байна. Даруй хур бороо буухыг бол *Хур буулгах тэнгэр* мэдэж, нуур булаг, гол мөрнийг бузартуулж түүний тэнгэрийг нь уурлуулж болохгүй. Тийм бол хур бороо орохгүй юм уу эсхүл тэнгэр дуугарч аянга ниргэнэ гэдэг. Эх малын тэнгэр нь *Мялаан тэнгэр* болох тул мал сүрэгтээ онгон мал тавин түүний тэнгэрийг нь баясгаж байх хэрэгтэй. Гөрөөс амьтныг хамаарч байгаа тэнгэр нь *Манаан тэнгэр* болох тул ан гөрөө хийгээд барвал заавал өчиг уншиж мялаах хэрэгтэй. Ордос нутгийн Үнэгэн сан бол даруй энэхүү жишээ болно.

Монголын бөө мөргөлийн шашин, тэнгэрийг шүтэхээс гадна бас газар дэлхийг шүтдэг. Жишээлбэл: Бурхан халдун, Цаст хайрхан, Муна уул цаашилбал овоо онгон бүр багтана.

<sup>20</sup> Түн Дэ Фү, *Чингис хааны тэнгэрийн хүчний үзэлт ба түүний онцлог*, Өвөрмонголын нийгмийн шинжлэх ухаан, Монгол, 1990. 2 хугацаа, 21-р нүүр

<sup>21</sup> Эрдэмт, *Монголын нууц товчоон дахь “Тэнгэр”-ийг өгүүлэх нь*, Өвөрмонголын нийгмийн шинжлэх ухаан, 1986 оны 2-р хугацаа; 40 нүүр, 29 нүүр

“*Монголын нууц товчоон*”-д гардаг Хурхунаг гэдэг газрын “*саглагар мод*”, Хатан гол нь бүр бөөгийн шашны шүтдэг зүйл байсан юм.

Малчин ардын дунд өнө удаан жилээр уламжлагдан ирсэн энэхүү бөө мөргөлийн тухай олон арвин үзэгдлүүдийн дотроос Чингис хаан өөрийнхөө улс гүрнийг засах явцад аж ахуй, цэрэг дайн, ардын амьдрал, үйлдвэрлэлийн хэрэгсэл зэрэгт ахиулах үйлдэлтэй зүйлүүдийг шилэн сонгож, чадамгайгаар ашиглаж, шүүмжлэлтэйгээр хүлээн авав. Чингис хааны тал нутгийн амь ахуйгаа хамгаалах үзэл ухамсар нь түүний “Тэнгэрийн хүчний үзэлт”-д тохирсон үзэл санаа болох юм. Тэр нь тэнгэрийг шүтэх бөө мөргөлийн шашнаас ямар хувиралтгүйгээр үүсч буй болсон биш харин яг түүний тэнгэрийн хүчний үзэлт мэт бөө мөргөлийн шашны доторх ашигтай зүйлийг үлдээн сонгон шилж аваад аль олон ашиггүй назгай зүйлийг орхиж хаяад буй болсон юм. Тухайн түүхэн цаг үед хааны амь ахуйг хамгаалах тухай үг яриа нь ардын дунд зөрчиж үл болох эрхбиш журамлах төмөр мэт бат ёс байсан юм. Ингээд зохих нэгэн хугацааг өнгөрөөсний дараа тэр нь хууль цаазын зүйл болон эмхтгэгдэн бичигдэж бодтой шийтгэх эрүүгийн хууль болон төгөлдөржсөн байдаг.

Дахиад хэлбэл, Чингис хаан бол ардчиллыг бадруулан журмыг эрхэмлэж жам ёсыг хүндэтгэдэг хаан байсан тул нийт олон монголчуудын сүсэг бишрэл, зан даатгалыг хүндэд үзэн өөрийнхөө үг яриа үйл ажиллагааг ардын сэтгэлд нийцүүлэхийг гүн сэтгэн тусгадаг байсан юм. Тухайн үеийн малчин ардын зан заншлын доторх зарим охь шилдэг зүйлийг сонгон шилж амь ахуйг хамгаалах хууль цаазын хүрээ хэвчээндээ оруулж дахин нийт монголын хэвчээнд дэлгэрүүлэн явагдуулдаг байсан юм. Даруй усыг бузарлаж болохгүй зан заншилд урсгал усны дотор хувцас хунараа угааж огт болохгүй байдаг дүрэм ардын дунд уламжлагдан чанга журамласаар иржээ.

Сүүлээр нь “*Хүмүүс голын усанд угаах, хуучин хувцас хунараа угааж болохгүй*” гэсэн хууль цааз тогтоож, бүх монголын цэрэг ардын дунд хэрэгжүүлээд зөрчигсдийг чангаар шийтгэдэг байсан юм. Чингис хааны иймэрхүү тал нутгийн амь ахуйгаа хамгаалах тухай үйл ажиллагаа үг яриан дээрээ журамлах үзэл санааны дүрэм горим, хууль цааз зэрэг үзэл ухамсрын хэлбэрийг бид “*Чингис хааны тал нутгийн амь ахуйгаа хамгаалах үзэл ухамсар*” гэж нэрлэсэн юм.

“Агуулгын товч” өгүүлэлд Чингис хааны тал нутгийн амь ахуйгаа хамгаалах тухай үзэл ухамсрыг түүх болон гүн ухааны талаас шинжлээд, Чингис хааны Тэнгэр - Хөх мөнх тэнгэр - Тэнгэрийн хүчний тухай ертөнцийн үзэлтээс ирэлттэй болохыг нотлох, тэр нь ардын заншлын жам ба хууль цаазын хэлбэрээр оршиж, урт удаан түүхэн явцад байгалийн эвдэгдлийг сэргийлэн амь ахуйн тэнцүүрийг батлахад зохих нөлөө үзүүлснийг анхааран шинжлэв.

“Зангилаа үг” Чингис хаан, амь ахуй, үзэл ухамсар, ирэлт

Агуу хүн Чингис хааны амь ахуйгаа хамгаалах үзэл ухамсар нь түүний үг яриа, үйл ажиллагаа дээр илрэхээр үл барам бас улс гүрнийг засах Их Монгол хаант улсын хууль цаазад нь ноороглон бичигдсэн байна. Чингис хаан ази европын өргөн уудам газар нутгийг эзэлсэн хаан эзэн болсны хувьд амь ахуйг хамгаалах үзэл ухамсраа адил бус аймаг угсаатны дотор хэрэгжүүлж, тал нутгийн өргөн хэвчээнээ амь ахуй орчин тойрноо хамгаалахыг зорьсон байна.